

ᠰᠤᠬᠤᠪᠠᠭᠠᠲᠤᠷ ᠠᠶᠢᠮᠠᠭ ᠳᠠᠬᠤ ᠲᠥᠷᠢᠶᠢᠨ
ᠠᠭᠤᠳᠢᠲᠤᠨ ᠭᠠᠰᠠᠷ

СҮХБААТАР АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН
АУДИТЫН ГАЗАР



НИЙЦЛИЙН АУДИТЫН ТАЙЛАН

АУДИТЫН СЭДЭВ: ОРОН НУТГИЙН 2026 ОНЫ ТӨСВИЙН ТӨСӨЛД
ДҮГНЭЛТ ӨГӨХ

Дарга, тэргүүлэх аудитор Г.Даваа

Утас: 70518396 Цахим хаяг: Davaag@audit.gov.mn

Аудитын менежер М.Нарантуяа

Утас: 70512123 Цахим хаяг: Narantuyam@audit.gov.mn

Ахлах аудитор Ө.Золзаяа

Утас: 70512123 Цахим хаяг: Zolzayau@audit.gov.mn

Ахлах аудитор С.Аринунбаяр

Утас: 70512123 Цахим хаяг: Ariunbayars@audit.gov.mn

Ахлах аудитор Г.Болдбаатар

Утас: 70512123 Цахим хаяг: Boldbaatar@audit.gov.mn

Товчилсон үгийн тайлбар	2
Хүснэгтийн товъёг	3
БҮЛЭГ 1. Төсвийн хөтөлбөр, арга хэмжээний зорилтот түвшин, шалгуур үзүүлэлтийг тодорхой хэмжигдэхүйц байдлаар тогтоон, зарим орлого, зарлагын тооцооллыг үндэслэлтэй боловсруулаагүй байна	6
1.1 Орон нутгийн төсвийн орлогын төлөвлөлтийн судалгааг оновчилж, гүйцэтгэлийн хяналтыг сайжруулах нь орлого нэмэгдүүлэх бодит боломжийг бүрдүүлэхээр байна	6
1.2 Зарлагын төлөвлөлт өмнөх оноос буурсан хэдий ч, зарим зардлууд хууль эрх зүйн үндэслэлгүйгээр, төлөвлөлтийн шаардлага хангаагүй байдлаар тусгагдсан байна	8
1.3. Төсөвлөлтийн шаардлага хангаагүй төсөл, арга хэмжээг орон нутгийн төсвийн төсөлд тусгах зөрчил бүрэн арилаагүй байна	10
1.4 Өмнөх онтой харьцуулахад хөрөнгө оруулалтын төлөвлөлт зарим төсөлд зураг төсөв, техникийн баримт бүрдүүлэлт сайжирсан боловч ОНХС-ийн төлөвлөлтийн зарчим бүрэн хангагдаагүй байна	12
2.1 Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих санд төсөв баталж ажлын байрыг нэмэгдүүлэх шаардлага байна	13
2.2 Хөгжлийн төлөвлөгөөний төсөл, арга хэмжээ төсвийн төлөвлөлттэй уялдсан эсэхэд дүгнэлт өгөх боломжгүй байна	14
Холбогдох байгууллагын санал	15
ДҮГНЭЛТ:	19
ТӨСВИЙН ТӨСӨЛД ӨГӨХ САНАЛ:	19
ЗӨВЛӨМЖ:	20

Товчилсон үгийн тайлбар

ААНОАТ	Аж ахуйн нэгжийн орлогын албан татвар
АДБОУБ	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Байгууллага
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
АТБӨЯХАТ	Авто тээврийн болон өөрөө явагч хэрэгслийн албан татвар
АЗДТГ	Аймгийн засаг даргын тамгын газар
СТСХ	Санхүү төрийн сангийн хэлтэс
ТАБ	Төрийн аудитын байгууллага
ОНӨААТҮГ	Орон нутгийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газар
ЗДТГ	Засаг даргын тамгын газар
ИНХ	Иргэдийн нийтийн хурал
ИТХ	Иргэдийн төлөөлөгчдийн хурал
СӨХ	Сууц өмчлөлийн холбоо
УТП	Үйлдвэрлэл технологийн парк

НА	Нийцлийн аудит
НА	Нотлох ажил
НД	Нийгмийн даатгал
ТБОНӨХБАҮХАТ	төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах
ОНХС	Орон нутгийн хөгжлийн сан
ОНХНС	Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сан
ОНӨААТҮГ	Орон нутгийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газар
СБА	Сүхбаатар аймаг
СТСХ	Санхүү төрийн сангийн хэлтэс
ТЭЗҮ	Техник эдийн засгийн үндэслэл
ҮХХХБООТ	Үл хөдлөх хөрөнгө худалдан борлуулсны орлогын албан татвар
ХХОАТ	Хувь хүний орлогын албан татвар
ХХК	Хязгаарлагдмал хариуцлагатай компани

Хүснэгтийн товьёг

№	Тайлбар	Хуудасны дугаар
1	Эрх зүйн үндэслэлгүй төлөвлөсөн тэтгэмжийн судалгаа	8
2	Төлөвлөлтийн шаардлага хангаагүй төсөл арга хэмжээний жагсаалт	9-10

Аудит хийх үндэслэл, бүрэн эрх

Аудитын зорилт, хамарсан хүрээ, стандарт, арга зүйн талаарх мэдэгдэл

Аудитыг Улсын Их Хурлын төсвийн Байнгын хорооны “Аудитын сэдэв батлах тухай” 2024 оны 5 дугаар тогтоол, Монгол Улсын Ерөнхий аудиторов 2024 оны “Төрийн аудитын байгууллагын 2025 онд гүйцэтгэх аудитын төлөвлөгөө батлах тухай” А/108 дугаар тушаалыг тус тус үндэслэн Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.-д заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд

	гүйцэтгэсэн.
Аудитын зорилт	Орон нутгийн төсвийн төсөлд болон төсвийн хөрөнгийн үр ашгийг дээшлүүлэх, орлого нэмэгдүүлэх талаар санал боловсруулж аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд оруулахад аудитын зорилт чиглэгдсэн.
Аудитын хамарсан хүрээ	Аудитад Сүхбаатар аймгийн Засаг даргын эрхлэх асуудлын хүрээнд 2025 оны төсвийн төслийг төлөвлөж, тайлагнах АЗДТГ, СТСХ, Татварын хэлтэс болон орон нутгийн 2023-2025 оны төсвийн орлого, зарлагын гүйцэтгэл, төсвийн орлого бүрдүүлж байгаа хуулийн этгээдийг хамруулав.
Аудитын арга зүй, шалгуур үзүүлэлт	Аудитыг гүйцэтгэхэд АДБОУБ /INTOSAI/-ы үндэслэн боловсруулсан Стандартын хорооноос баталсан АДБОУС-100, АДБОУС-300, АДБОУС-3000-д нийцүүлэн баталсан Монгол Улсын Төрийн аудитын стандарт MNS 6817-1:2020 “Төрийн аудит –Тулгуур зарчим”, MNS 6817-5:2020 “Төрийн аудит. Гүйцэтгэлийн аудит” стандартад заасан зарчим, арга зүйд нийцүүлэн, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/106 дугаар тушаалаар баталсан ТАБ-аас аудит хийх журам, гүйцэтгэлийн аудит хийх аргачлалыг ашиглан холбогдох албан тушаалтнуудтай ярилцлага хийх, асуулга лавлагаа, тодруулга авах болон судалгааг харьцуулах, нэгтгэх, дүн шинжилгээ хийх зэрэг аудитын арга зүйг ашиглалаа.
Аудитын бүрэлдэхүүн, хугацаа	Аудитын төлөвлөгөөг 2025 оны 9 дүгээр сарын 10-ны өдрөөс эхлэн боловсруулж, гүйцэтгэлийн үе шатны ажлыг 10 дугаар сарын 01-ээс 11 дүгээр сарын 25, тайлагналын үе шатыг 11 дүгээр сарын 26-аас 12 дугаар сарын 01-нд гүйцэтгэж холбогдох албан тушаалтанд хүргүүлээ.



СҮХБААТАР АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗРЫН ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОРЫН ТУШААЛ

2025 оны 12 сарын 02 өдөр

Дугаар А/96

Баруун-Урт сум

Нийцлийн аудитын тайланг
баталгаажуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.1 дэх хэсэг, 20 дугаар зүйлийн 20.1, 20.4 дэх хэсэг, 29 дүгээр зүйлийн 29.4 дэх хэсэг, Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны 12 дугаар сарын 22-ны өдрийн А/106 дугаар тушаалаар баталсан “Төрийн аудитын байгууллагаас аудит хийх журам”-ын 18 дугаар зүйлийн 18.9 дэх хэсэг, Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2023 оны 10 дугаар сарын 05-ны өдрийн “Эрх шилжүүлэх тухай” А/102 дугаар тушаалын 4 дүгээр хавсралтын 1.4 дэх заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. “Орон нутгийн 2026 оны төсвийн төсөлд дүгнэлт өгөх” нийцлийн аудитын тайланг баталгаажуулсугай.

2. Аудитын тайланг аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурал, Засаг дарга, БОНХОБТХ-т хүргүүлж ажиллахыг ахлах аудитор (Ө.Золзаяа)-д үүрэг болгосугай.

3. Аудитаар өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлэх төлөвлөгөөг 2026 оны 01 дүгээр сарын 02, биелэлтийг 2026 оны 10 дугаар сарын 02-ны өдрийн дотор Сүхбаатар аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэхийг аймгийн Засаг дарга (М.Идэрбат) болон Бүс, орон нутгийн хөрөнгө оруулалт, бодлого, төлөвлөлтийн хэлтсийн дарга (Г.Мөнхзаяа) нарт хариуцуулсугай.

4. Аудитын тайланг баталгаажуулснаас хойш 14 хоногт багтаан аудитын ажлын болон нотлох баримтыг архивын нэгж болгон архивд хүлээлгэн өгөхийг ахлах аудитор (Ө.Золзаяа), аудитор (Г.Оюунболд), аудитор (О.Барчидгүнсэн), аудитор (Б.Мөнхбамбар) нарт үүрэг болгосугай.

5. Энэхүү тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж, холбогдох арга хэмжээ авч ажиллахыг аудитын менежер (М.Нарантуяа)-д даалгасугай.

ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

Г.ДАВАА

D:\Бичиг хэрэг\2025\Тушаал\А тушаал 2025.docx

2225010224

БҮЛЭГ1. Төсвийн хөтөлбөр, арга хэмжээний зорилтот түвшин, шалгуур үзүүлэлтийг тодорхой хэмжигдэхүйц байдлаар тогтоон, зарим орлого, зарлагын тооцооллыг үндэслэлтэй боловсруулаагүй байна.

1.1 Орон нутгийн төсвийн орлогын төлөвлөлтийн судалгааг оновчилж, гүйцэтгэлийн хяналтыг сайжруулах нь орлого нэмэгдүүлэх бодит боломжийг бүрдүүлэхээр байна.

1.1.1 Санхүү, төрийн сангийн хэлтсээс манай байгууллагад ирүүлсэн орон нутгийн 2026 оны төсвийн төслийг хүргүүлэх тухай 2025 оны 11 дүгээр сарын 20-ны өдрийн 06/1350 тоот албан бичигт төсвийн төслийн хавсралтыг ирүүлээгүй байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.5.1-т заасантай нийцэхгүй байгаа бөгөөд хуулийн хугацаанд дүгнэлт гаргахад хүндрэл үүсгэж байгаа тул цаашид анхаарах нь зүйтэй юм.

1.1.2 Сангийн сайдын 2025 оны 11 дүгээр сарын 14-ний өдрийн 01/10180 албан бичгээр орон нутгийн 2026 оны төсвийн төсөл боловсруулж батлуулах, хэрэгжүүлэхэд баримтлах чиглэл удирдамжийг хүргүүлсэн байна.

1.1.3 Аймгийн 2025 оны төсвийн суурь орлогыг 31,719.5 сая төгрөгөөр төлөвлөн Сангийн яаманд хүргүүлж, 41,894.4 сая төгрөгөөр хянаж, баталсан байна.

1.1.4 Аймгийн СТСХ-ээс 2026 оны жилийн төсвийн орлогыг 42,171.8 сая төгрөг байхаар төлөвлөжээ. Энэ нь 2025 оны төсөвтэй харьцуулахад 1,179.2 сая төгрөгөөр бууруулсан байна.

1.1.5 Агаарын бохирдлын төлбөрийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1-д зааснаар аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурал олборлосон түүхий нүүрсний төлбөрийн хувь, хэмжээг килограмм тутамд 1–2 төгрөгийн хязгаарт багтаан тогтоох ёстой. Гэвч нүүрсний төлбөрийн хувь хэмжээг тогтоосон ИТХ-ын шийдвэр гараагүй нөхцөлд агаарын бохирдлын төлбөрийн орлогыг өмнөх оны гүйцэтгэлд тулгуурлан килограмм тутамд 2 төгрөгөөр тооцож, 6,000.0 сая төгрөгөөр төлөвлөсөн нь хууль, эрх зүйн нийцэл хангагдсан бодитой төлөвлөлт гэж үзэх боломжгүй байна.

Иймд төсвийн орлогын төлөвлөлтийг боловсруулахдаа уг татвар, төлбөртэй холбоотой эрх зүйн актуудыг төсвийн төслийн хамт ИТХ-д өргөн мэдүүлж, нэгэн зэрэг батлуулах нь зүйтэй. Тухайлбал, аймгийн Засаг дарга, Татварын газар, СТСХ нар салбар хоорондын уялдаа холбоог ханган ажиллаж, төлбөрийн хувь хэмжээг тогтоох шийдвэр гаргах нөхцөлийг бүрдүүлснээр эрх зүйн актын хүчин төгөлдөр байдлыг хангаж, татварын бааз, суурийг бодитой тооцох боломж бүрдэнэ.

1.1.6 Баруун-Урт–Бичигт чиглэлийн 152 км тусгай зориулалтын авто замын ажлыг гүйцэтгэгч “Монгол зам групп” ХХК нь түгээмэл тархацтай ашигт малтмалыг тусгай зөвшөөрөлгүй ашиглах, зөвшөөрсөн талбайг хэтрүүлэх, Засгийн газрын тогтоолоор тогтоосон хугацааг зөрчих, мөн суурьшлын бүс болон Баруун-Урт сумын ерөнхий төлөвлөгөөтэй давхцуулах зэрэг зөрчил гаргасан нь мэргэжлийн байгууллагын дүгнэлтээр 181.3 сая төгрөгийн хохирол учруулсан болох нь тогтоогдсон байна.

Гэтэл Засгийн газрын 2014 оны 222 дугаар тогтоол /Засгийн газрын 2025 оны 82 тоот тогтоолоор шинэчлэгдсэн/-д заасан түгээмэл тархацтай ашигт малтмалын борлуулалтын үнэлгээг аймгийн ИТХ батлаагүйгээс дараах сөрөг үр дагавар бий болсон байна. Үүнд:

- Аймгийн төсөвт төвлөрөх боломжтой түгээмэл тархацтай ашигт малтмал ашигласны орлого тасарсан;
- Аймгийн хөгжлийн ерөнхий төлөвлөгөө болон суурьшлын бүсийн зохицуулалтыг зөрчсөн;
- ИТХ нь холбогдох үнэлгээг батлаагүй, өмнөх аудитаар өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлээгүйгээс аймгийн төсөвт төвлөрөх ёстой орлого алдагдсан.

Тус зөрчилтэй холбоотойгоор тооцсон 181.3 сая төгрөгийн нөхөн төлбөрийг Байгаль орчин, уур амьсгалын сангийн дансанд төвлөрүүлэхээр шийтгэлийн хуудас бичигдсэн боловч энэхүү төлбөрийг орон нутгийн төсөвт төвлөрүүлэх чиглэлд дахин зөвшилцөх, холбогдох байгууллагууд хамтран ажиллаж эрх зүйн зохицуулалтыг бүрдүүлэх нь зүйтэй. Ийм арга хэмжээ авч хэрэгжүүлснээр орон нутгийн орлогыг нэмэгдүүлэх, хүрээлэн буй орчинд учруулсан хохирлыг нөхөн төлүүлэх, ашигт малтмалын ашиглалтын хяналт, удирдлагын үр нөлөөг сайжруулах боломж бүрдэнэ.

1.1.7 Монгол Улсын Авто тээврийн болон өөрөө явагч хэрэгслийн албан татварын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д албан татварын жилд ногдуулах дээд, доод хязгаарыг заасан. Мөн тус зүйлийн 5.3-д аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал (ИТХ) татварын хэмжээг хуулийн дээд хязгаараас хэтрүүлэхгүйгээр тогтоох эрхтэйг зохицуулсан. Аймгийн ИТХ-аас 2011 оны 3 дугаар сарын 29-ний өдрийн 03 тоот тогтоолоор авто тээврийн хэрэгсэлд ногдох татварын хэмжээг 2,500-550,000 төгрөг байхаар тогтоосон байна. Хуульд заасан хүрээнд татварын хэмжээг шинэчлэн 1,000-10,000 төгрөгөөр нэмэгдүүлэн тогтоох тохиолдолд орон нутгийн төсвийн орлогыг нэмэгдүүлэх боломжтой.

1.1.8 Аймгийн Засаг даргын 2025 оны А/176 тоот захирамжийн хүрээнд уул уурхайн үйл ажиллагаа эрхэлдэг аж ахуйн нэгжүүдтэй хамтран ажиллах гэрээг шинэчлэн байгуулсан байна. Үүний үр дүнд 2024 онд 14 компанитай нийт 2,201.0 сая төгрөгийн хамтын ажиллагааны гэрээ байгуулсан бол 2025 онд 19 компанитай байгуулж гэрээний хэмжээ 3,880.0 сая төгрөгт хүрч, өмнөх оноос 1,679.0 сая төгрөгөөр нэмэгдсэн үзүүлэлттэй байна. Энэ нь орон нутгийн орлого, хамтын ажиллагааны цар хүрээ, хариуцлагатай уул уурхайн бодит хувь нэмэр өсөж буйг илтгэж байна. Тухайн онд 3,880.0 сая төгрөг төвлөрөхөөс 2025 оны 11-р сарын 19-ны байдлаар 3,278.0 сая төгрөг төвлөрч 602.0 сая төгрөгийн орлого дутуу төвлөрүүлсэн. Гэрээгээр төсөвт орох мөнгөн дүн нэмэгдэж байгаа боловч төсөвт бүрэн төвлөрүүлэх арга хэмжээ авах шаардлагатай байна.

1.1.9 Ус рашааны нөөц ашигласны төлбөрийн орлогыг 900.0 сая төгрөгөөр Эм эл цахиурт овоо, Монгол Жүюаньли, Цайртминерал, Эрээнтөлгой ХХК-уудаас төвлөрүүлэхээр төсвийн төсөлд тусгаж Сангийн яам 907.5 сая төгрөгөөр хянаж баталгаажуулсан байна.

Аймагт үйл ажиллагаа явуулж буй 4 аж ахуйн нэгж байгууллагаас гадна, 2025 онд үйлдвэрлэл, шавхан зайлуулах зориулалтаар дараах 9 аж ахуйн нэгж байгууллагатай ус ашиглах дүгнэлт гаргуулан гэрээ байгуулсан байна. Ингэснээр нийт 13 аж ахуйн нэгжээс 2025 оны 10 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар 826.0 сая төгрөгийн орлого төвлөрсөн. Гэсэн хэдий ч ус, рашааны нөөц ашигласны төлбөрт зарим аж ахуйн нэгжийн орлогыг тусгаагүй байна.

Гэрээний дүнг бүрдүүлж буй ААН-үүд:

- Дорнын чулуулаг ХХК – 19.3 сая₮
- Бичигт шим майнинг ХХК – 0.9 сая₮
- Хунт-Өгөөж ХХК – 14.4 сая₮
- Сунхунголд ХХК – 24.1 сая₮
- Премиумкүүл корпораци ХХК – 16.9 сая₮
- Бадмаараг хаш ХХК – 113.8 сая₮
- Эрдэнийн босго ХХК – 150.4 сая₮
- Нагааранз ХХК – 97.4 сая₮
- Олгойбулаг ХХК – 189.0 сая₮

Дээрх 9 компанитай байгуулсан гэрээний 2025 оны гүйцэтгэлийн түвшнийг хадгалж, 2026 онд гэрээг шинэчлэн ажиллавал аймгийн төсөвт нэмэлт 626.2 сая төгрөгийн орлогыг нэмж төлөвлөх боломжтой байна. */Дээрх аж ахуйн нэгж байгууллагатай байгуулсан 2025 оны гэрээг дүгнээгүй байгаа бөгөөд гэрээний үнийн дүнгийн 50%-аас багагүй дүнгээр 2026 оны орлогын төлөвлөгөөг нэмэгдүүлэх боломжтой юм./*

1.2 Зарлагын төлөвлөлт өмнөх оноос буурсан хэдий ч, зарим зардлууд хууль эрх зүйн үндэслэлгүйгээр, төлөвлөлтийн шаардлага хангаагүй байдлаар тусгагдсан байна.

1.2.1 Орон нутгийн 2026 оны төсвийн зарлагыг 42,171.8 сая төгрөгөөр төлөвлөсөн. Энэ нь 2025 оны батлагдсан зардлаас 1,179.2 сая төгрөгөөр буурсан байна.

1.2.2 Аймгийн ИТХ-ын төсвийн төсөлд төлөөлөгчийн үйл ажиллагаа болон чадавхжуулах зардлыг 290.0 сая төгрөгөөр (нэг төлөөлөгчид 10.0 мянган төгрөг ногдохоор тооцсон), мөн 2025 оны төсвийн жилд хэрэгжүүлээгүй үйл ажиллагаанд 80.0 сая төгрөгөөр тус тус төлөвлөсөн байна.

Засгийн газрын 2021 оны 402 дугаар тогтоолоор баталсан журмын дагуу төлөөлөгчийн үйл ажиллагаа болон тэдгээрийг чадавхжуулах зардлыг тооцоход 145.0 сая төгрөгийг төлөвлөх боломжтой бөгөөд үүнээс давсан 145.0 сая төгрөгийн зардал нь давхардуулан төлөвлөсөнд тооцогдож байна. Иймд энэхүү давхардсан зардал нь хууль тогтоомжийн шаардлагад нийцэхгүй байна.

Мөн 2025 оны төсвийн тодотголоор хасагдсан зардлыг 2026 оны төсөвт дахин төлөвлөсөн нь өмнөх оны төсвөө давтан батлахтай адил бөгөөд энэ нь Төсвийн тухай хуулийг ноцтой зөрчсөн нөхцөл байдал болохыг анхааруулъя.

Иймд дээр дурдсан үндэслэлүүдийг хянан үзэж, хууль зүйн шаардлагад нийцүүлэх үүднээс нийт 225.0 сая төгрөгийн илүү төлөвлөгдсөн зардлыг төсвөөс хасаж тооцох чиглэлийг СТСХ-т өгч байна.

1.2.3 Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 78 дугаар зүйлийн 78.1-д “сумдын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал болон бүх

шатны Засаг дарга ээлжит сонгуулийн үр дүнд албан тушаалаасаа чөлөөлөгдсөн тохиолдолд урьд эрхэлж байсан албан тушаалын зургаан сарын цалинтай тэнцэх хэмжээний нэг удаагийн тэтгэмж олгоно” гэж заасан. Энэ зохицуулалтаар зөвхөн **ИТХ-ын дарга болон бүх шатны Засаг дарга** нэг удаагийн тэтгэмж авах эрхтэй бөгөөд **орлогч дарга нарын тэтгэмжийн тухай ямар нэгэн эрх зүйн зохицуулалт байхгүй** байна.

Гэтэл Асгат, Баяндэлгэр, Дарьганга, Онгон, Түвшинширээ, Халзан сумдад ажлаас чөлөөлөгдсөн орлогч дарга нарт нийт **67.3 сая төгрөгийн тэтгэмж** төлөвлөсөн нь холбогдох хууль зүйн зохицуулалтгүй, үндэслэлгүй зардлыг төсөвт тусгасан зөрчил болох бөгөөд цаашид ТЕЗ-ын санхүүгийн нэгтгэсэн тайлангийн дүгнэлтэд нөлөөлөхөөр байна.

Мөн 2024 оны сонгуулийн үр дүнгээр чөлөөлөгдсөн сумын болон багийн Засаг дарга нарт 2025 онд **121.5 сая төгрөгийн тэтгэмж** олгосон боловч уг зардлыг 2026 оны төсвийн төсөлд дахин төлөвлөсөн нь Төсвийн тухай хууль болон төсвийн төлөвлөлтийн зарчмыг зөрчсөн, гүйцэтгэл нь бүрэн хийгдсэн зардалд дахин хөрөнгө төлөвлөсөн зөрчил болохоор байна.

№	Сум	Албан тушаал	Тэтгэмж
1	Асгат	Засаг дарга	12.9
		Засаг даргын орлогч	11.2
2	Баяндэлгэр	Засаг даргын орлогч	11.2
3	Дарьганга	Засаг дарга	12.9
		Засаг даргын орлогч	11.2
		Багийн засаг дарга	17.5
4	Мөнххаан	Багийн засаг дарга	35.0
5	Онгон	Засаг даргын орлогч	11.2
6	Түвшинширээ	Засаг даргын орлогч	11.2
7	Түмэнцогт	Засаг дарга	12.9
		Багийн засаг дарга	17.5
8	Халзан	Засаг дарга	12.9
		Засаг даргын орлогч	11.2
ДҮН			188.8

Иймд тайлант жилд олгосон, түүнчлэн холбогдох хууль, эрх зүйн актуудад нийцэхгүйгээр төлөвлөгдсөн тэтгэмжийн **нийт 188.8 сая төгрөгийн зардлыг 2026 оны төсвийн төслөөс хасаж тооцох** талаар Санхүү, төрийн сангийн хэлтэс болон Аймгийн Засаг даргад зөвлөж байна.

1.2.4 Төсвийн төслийн нэгтгэлд гэрээгээр гүйцэтгүүлэх арга хэмжээ (ОНӨҮГазар)-нд 1,255.0 сая төгрөг төлөвлөжээ. Уг арга хэмжээг нарийвчлан авч үзэхэд Сүхбаатар соёл амралтын хүрээлэн, Сүхбаатар хөгжил ҮТП, Бичигт их өргөө, Сүхбаатар нийтлэг үйлчилгээ зэрэг ОНӨААТҮГ-т санхүүгийн дэмжлэг олгохоор тусгасан байна. Дээрх аж ахуйн тооцоот газрууд нь үндсэн үйл ажиллагааны орлогоороо санхүүгийн эх үүсвэрийг хариуцан ажиллах боломжтой тул санхүүгийн дэмжлэгийг хасах, давтан тооцоолол хийж бууруулах арга хэмжээ авч ажиллах нь зүйтэй байна. Тухайлбал ОНӨААТҮГ-д үндсэн үйл ажиллагааны үндсэн дээр дараах орлогыг олох боломжтой байна.

- Сүхбаатар соёл амралтын хүрээлэн ОНӨААТҮГ-ын үйл ажиллагаа явуулах бүтээн байгуулалтын ажлыг улсын комисс хүлээн авснаар худалдаа үйлчилгээний цэгийн түрээс, автомат тоглоом, ногоон байгууламжийн арчилгаа, усалгааны ажлын хөлс;
- Сүхбаатар хөгжил ҮТП нь түрээс, сүүний үйлдвэрийн орлого;
- Сүхбаатар нийтлэг үйлчилгээ ОНӨААТҮГ нь гэрээний төлбөр болон буудал, зоогийн газрын үйл ажиллагаа зэргээс орлого олж санхүүгийн үйл ажиллагааны тодорхой хэсгийг санхүүжүүлэх боломжтой юм.

Харин Бичигт их өргөө ОНӨААТҮГ нь бичигт боомтод байрлалтай барилгын түрээсийн орлогоос өөр ямар орлого олж үйл ажиллагаагаа санхүүжүүлэх нь тодорхойгүй бөгөөд жил бүр орон нутгийн төсвөөс санхүүгийн дэмжлэг авч байна. Иймд уг ОНӨААТҮГ-ийг

эрхэлж байгаа үйл ажиллагааг Орон нутгийн өмчийн газарт хариуцуулж татан буулгах саналыг ИТХ-д уламжлах нь зүйтэй юм.

1.2.5 Усан хангамж, ус цэвэршүүлэх байгууламж, бохир ус цэвэрлэх байгууламжийн үйл ажиллагаанд 549.2 сая төгрөгийн татаас олгохоор төсөвлөсөн байна. Монгол Улсын Засгийн газрын 2012 оны 6 дугаар сарын 13-ны өдрийн **209 дүгээр тогтоолд** гэр хорооллын хэрэглэгчдийн усны үйлчилгээний төлбөрийн зөрүү алдагдлыг орон нутгийн төсвөөс санхүүжүүлэх зохицуулалттай бөгөөд энэхүү тогтоолд үндэслэн тооцоо хийвэл **163.0 сая төгрөгийн** татаас олгохоор байна. Харин ус цэвэршүүлэх болон бохир усны байгууламжийн **урсгал зардалд** 386.2 сая төгрөгийг орон нутгийн төсвөөс санхүүжүүлэх эрх зүйн үндэслэл байхгүй бөгөөд хуульд нийцээгүй төлөвлөлт хийгдсэн байна. Энэ төсөв батлагдсан тохиолдолд хууль зөрчсөн болох бөгөөд аудитын дүгнэлтэд нөлөөлөхөөр байна. Иймд хуульд нийцэхгүй, үндэслэлгүйгээр суурь зардалд тусгасан дээрх **386.2 сая төгрөгийн** санхүүжилтийг 2026 оны төсвийн төслөөс хасаж тооцохыг зөвлөж байна.

1.3. Төсөвлөлтийн шаардлага хангаагүй төсөл, арга хэмжээг орон нутгийн төсвийн төсөлд тусгах зөрчил бүрэн арилаагүй байна.

1.3.1 Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний төсвийн төсөлд 2026 оноос эхлэн хэрэгжүүлэхээр тусгасан 13,324.6 сая төгрөгөөр санхүүжих 51 шинэ ТАХ-ний 10,779.8 сая төгрөг буюу 80.9 хувийг орон нутгийн хөгжлийн сангаас 1,056.9 сая төгрөг буюу 7.9 хувийг орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар, 353.3 сая төгрөг буюу 2.7 хувийг их засварын зардлаар, 694.4 сая төгрөг буюу 5.2 хувийг замын сангаар, 440.1 сая төгрөг буюу 3.3 хувийг Байгаль хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээний зардлаар хэрэгжүүлэхээр тусгасан байна.

1.3.2 Төсөл арга хэмжээний 22.0 хувийг барилга байгууламж, 12.4 хувийг бараа, 12.6 хувийг их засвар, 29.9 хувийг ажил, 7.4 хувийг урсгал зардал, 15.7 хувийг ТЭЗҮ боловсруулах төсөл арга хэмжээ эзэлж байна.

1.3.3 Шинээр төлөвлөгдсөн 7,097.3 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 29 төсөл арга хэмжээ магадлалаар баталгаажсан зураг төсөвгүй, төсөвт өртгийн тооцоо судалгаагүй, техникийн тодорхойлолт, үнийн судалгаагүй байгаа нь төсөвлөлтийн шаардлагыг хангахгүй байна.

Төлөвлөлтийн шаардлага хангаагүй төсөл арга хэмжээний жагсаалт

№	Төсөл арга хэмжээ	Төсөвт өртөг /мян.төг/	2026 онд санхүүжих дүн /мян.төг/	Төсөл арга хэмжээний ангилал	Эх үүсвэр	Төсөвлөлтийн шаардлага хангаагүй
1	Гал унтраах машин /Баяндэлгэр/	200,000.0	200,000.0	Бараа	ОНХС	Техникийн тодорхойлолт, үнийн судалгаагүй
2	Соёл амралтын цогцолбор / Түмэнцогт сум/	700,000.0	432,266.8	Ажил	ОНХС	Магадлалаар баталгаажсан зураг төсөвгүй
3	Сүхбаатарын талбайн өргөтгөл засвар	650,000.0	650,000.0	Ажил	ОНХС	Магадлалаар баталгаажсан зураг төсөвгүй
4	0.4 кВ-ын ЦДАШ-н өргөтгөл шаардагдах тоног төхөөрөмж худалдан авах /Наран сум/	78,000.0	78,000.0	Бараа	ОНХС	Техникийн тодорхойлолт, үнийн судалгаагүй
5	Цэцэрлэг 150 хүүхдийн /3-р баг/	1,600,000.0	800,000.0	Ажил	ОНХС	Магадлалаар баталгаажсан зураг

“Сүхбаатар аймгийн 2026 оны төсвийн төсөлд өгсөн дүгнэлт”

						төсөвгүй
6	Скэйт төв (Баруун-Урт)	385,571.6	385,571.6	Ажил	ОНХС	Магадлалаар баталгаажсан зураг төсөвгүй
7	Сүү, сүүн бүтээгдэхүүний үйлдвэрлэлийг нэмэгдүүлэх	300,000.0	300,000.0	Бараа	ОНХС	Техникийн тодорхойлолт, үнийн судалгаагүй
8	Барилга байгууламжийн буулгалтын зардал	400,000.0	400,000.0	Урсгал зардал	ОНХС	Төсөвт өртгийн тооцоо судалгаагүй
9	Хил орчмын дэглэмийг сахиулахад ангиудад дэмжлэг үзүүлэх /мотоцикл 8ш худалдан авах/	28,000.00	28,000.00	Бараа	ОНХС	Техникийн тодорхойлолт, үнийн судалгаагүй
10	Жижиг дунд үйлдвэрлэл эрхлэгчдийн үзэсгэлэн худалдаанд зориулж асар худалдан авах	200,000.00	200,000.00	Бараа	ОНХС	Техникийн тодорхойлолт, үнийн судалгаагүй
11	Нисэхийн цэцэрлэгт хүрээлэнгийн ногоон байгууламж тохижилтын ажил	290,000.00	290,000.00	Ажил	ОНХС	Магадлалаар баталгаажсан зураг төсөвгүй
12	Ногоон байгууламж усалгааны усны автомашин худалдан авах (Баруун-Урт сум)	80,000.00	80,000.00	Бараа	ОНХС	Техникийн тодорхойлолт, үнийн судалгаагүй
13	Төрийн албан хаагчийн гадаад арга хэмжээ сургалтын зардалд	100,000.0	100,000.0	Урсгал зардал	ОНТХО	Шалгуур үзүүлэлт, хүрэх түвшин тодорхойгүй
14	Төрийн албан хаагчийн нийгмийн баталгаа	500,000.0	500,000.0	Урсгал зардал	ОНТХО	Тооцоо судалгаа байхгүй.
15	Үйлдвэрчний эвлэлийн байрны тохижилтын ажилд дэмжлэг	50,000.0	50,000.0	Урсгал зардал	ОНТХО	Тохижилтын ажлын тооцоо судалгаагүй
16	Өвөлжилтийн бэлтгэл хангах	186,995.9	186,995.9	Бараа	ОНТХО	Төсөвт өртгийн тооцоо судалгаагүй
17	Орон сууцны дэмжлэг	220,000.0	220,000.0	Урсгал зардал	ОНТХО	Төсөвт өртгийн тооцоо судалгаагүй
18	ШШГТ -н ажилчдын орон сууцны засвар	20,000.0	20,000.0	Урсгал зардал	ИЗ	Төсөвт өртгийн тооцоо судалгаагүй
19	Усан спортын сургалтын төвийн засварын ажил	163,420.3	163,420.3	Ажил	ИЗ	Магадлалаар баталгаажсан зураг төсөвгүй
20	Замын засвар үйлчилгээ	694,393.2	694,393.2	Ажил	Замын сан	Магадлалаар баталгаажсан зураг төсөвгүй
21	Булгийн эхийг хашиж хамгаалах	28,000.00	28,000.00	Ажил	БХНСАХЗ	Магадлалаар баталгаажсан зураг төсөвгүй
22	Бэлчээрийн усан хангамж болон унд ахуйн зориулалтаар гаргасан худгуудад зөвшөөрөл олгож паспортжуулна.	6,731.00	6,731.00	Ажил	БХНСАХЗ	1 худгийг паспортжуулах өртөг тодорхой бус
23	Аймгийн төвийн ундны усан хангамжийн эх үүсвэрийн эрүүл ахуйн хориглолт, хязгаарлалтын бүсийг хашиж хамгаалах	42,300.00	42,300.00	ажил	БХНСАХЗ	Магадлалаар баталгаажсан зураг төсөвгүй
24	Газрын доорх усны мониторингийн цэгийн багаж тоног төхөөрөмж худалдаж авах	28,900.00	28,900.00	Бараа	БХНСАХЗ	Техникийн тодорхойлолт, үнийн судалгаагүй
25	Ойн менежментийн төлөвлөгөөг мэргэжлийн байгууллагаар хийлгэх	25,000.00	25,000.00	Бараа	БХНСАХЗ	Ажлын даалгаваргүй, төсөвт өртөг тодорхой бус
26	Аймгийн Агнуур зохион байгуулалтын судалгааг мэргэжлийн байгууллагаар хийлгэх	40,000.00	40,000.00	Бараа	БХНСАХЗ	Ажлын даалгаваргүй, төсөвт өртөг тодорхой бус
27	Аймгийн ан агнуур менежментийн төлөвлөгөөний хэрэгжилтийг хангах ажлын хүрээнд монгол тарвагыг сэргээн	30,000.00	30,000.00	Урсгал зардал	БХНСАХЗ	Ажлын даалгаваргүй, төсөвт өртөг тодорхой бус

нутагшуулах						
28	Ховор ан амьтанд биотехникийн арга хэмжээ авах	15,000.00	15,000.00	Урсгал зардал	БХНСАХЗ	Нөхөрлөлд суурилж гэрээгээр гүйцэтгүүлэх боловч хэдэн байршилд тус арга хэмжээг хэрэгжүүлэх нь тодорхой бус
29	Байгаль орчны багц хуулиуд, “Төрийн хяналт шалгалтын тухай”, “Зөрчлийн тухай”, “Зөрчил шалган шийдвэрлэх тухай” хуулийн хүрээнд хамтарсан хяналт шалгалтын ажлыг зохион байгуулах, зөрчил дутагдлыг арилгах	35,000.00	35,000.00	Урсгал зардал	БХНСАХЗ	БОГ-ын үндсэн үйл ажиллагааны урсгал төсвөөс санхүүжүүлбэл зохих хяналтын байцаагч нарын томилолт, шатахууны зардал байх тул хасуулах саналтай
Нийт дүн		7,097,312.0	6,029,578.8			

1.3.4. Аймгийн ОНХС болон ОНТХО-оор санхүүжих төсөл, арга хэмжээний захиалагч нь Аймгийн Засаг даргын Тамгын газар байх тул тоног төхөөрөмжийн төсөвт өртгийг ашиглагч байгууллагын ирүүлсэн техникийн тодорхойлолтод тулгуурлан тогтоох нь зөв аргачлал биш юм.

1.3.5. Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 12.1-д заасны дагуу захиалагч болох АЗДТГ нь тоног төхөөрөмжийн техникийн тодорхойлолтыг орон нутгийн төсвийн төсөл боловсруулах шатанд баталгаажуулж, батлагдсан техникийн тодорхойлолтод үндэслэн төсөвт өртгийн зах зээлийн судалгааг хийх шаардлагатай юм.

1.3.6. Мөн тоног төхөөрөмжийн төсөл, арга хэмжээг төсөвт тусгахдаа “Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг төлөвлөх, санхүүжүүлэх, хянах, тайлагнах журам”-ын 3.2.3.3 /холбогдох баримт бичиг, нотлох баримтаар баталгаажсан, төлөвлөлт, зорилтод нийцсэн, хэрэгцээ шаардлагад тулгуурласан байх/ дахь заалтыг дагаж мөрдөх буюу техникийн тодорхойлолт батлагдсан байх шаардлагатай байна.

1.4 Өмнөх онтой харьцуулахад хөрөнгө оруулалтын төлөвлөлт зарим төсөлд зураг төсөв, техникийн баримт бүрдүүлэлт сайжирсан боловч ОНХС-ийн төлөвлөлтийн зарчим бүрэн хангагдаагүй байна.

1.4.1 Аймгийн Засаг дарга орон нутгийн 2026 оны төсвийн төслийг 2025 оны 11 дүгээр сарын 24-ний өдөр ирүүлсэн нь Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.5.1-д заасан хугацааны шаардлагыг хангаагүй бөгөөд энэ нь төсвийн төслийн талаар хуулийн хугацаанд дүгнэлт гаргах боломж хязгаарлагдаж байгааг анхаарах нь зүйтэй.

1.4.2 Аймгийн 2026 оны орон нутгийн төсвийн төслийг боловсруулах үйл явц нь өмнөх онтой харьцуулахад сайжирч, төсвийн тооцооллын бодит байдал нэмэгдэн, байгууллагуудын уялдаа холбоо бэхэжсэн нь төсвийн төлөвлөлтийн чанарт эергээр нөлөөлсөн байна. Түүнчлэн гүйцэтгэлийн шинжилгээг төсвийн төсөлд тусгаж эхэлсэн нь төлөвлөлтийн оновчтой байдлыг дээшлүүлэх нөхцөл бүрдүүлжээ.

Гэсэн хэдий ч зарим салбарт тооцооллын нарийвчлал болон дүн шинжилгээний түвшин хангалтгүй хэвээр байгаа тул цаашид үр ашиг, нотолгоонд суурилсан төсөвлөлтийг үе шаттай сайжруулан хэрэгжүүлэх шаардлагатай байна.

1.4.3 Төсвийн захирагч бүр хөтөлбөрийн зорилтот түвшин, шалгуур үзүүлэлт болон хүрэх үр дүнг тодорхойлоогүй нь төсвийн үр ашгийг бууруулж, гүйцэтгэлийг бодитоор хэмжих

боломжийг хязгаарлахын зэрэгцээ хяналт, тайлагналын ил тод байдлыг алдагдуулах эрсдэлтэй байна.

Төсвийн төлөвлөлтийг боловсруулах явцад Төсвийн тухай хуулийн шаардлагыг бүрэн баримталж, Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын төлөөлөгчдийг шаардлагатай мэдээллээр ханган ажиллах нь төсвийг үр ашигтай, нотолгоонд суурилсан байдлаар батлах нөхцөлийг бүрдүүлнэ.

Тухайлбал, төсвийн зарлагыг хөтөлбөрөөр төлөвлөхдөө төслийн ач холбогдол, эрэмбэ, хэрэгцээ шаардлагын үнэлгээ, олон нийтийн оролцоо, төсөвлөлтийн норм, норматив, батлагдсан стандарт болон зураг төсвийг тусган тодорхойлох нь төсвийн үр дүн, үр нөлөөг бодитоор бий болгох үндэс болно.

БҮЛЭГ 2: Орон нутгийн 2026 оны төсвийг хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, ЖДҮ-ийг хөгжүүлэх бодлогоор чиглүүлэн төлөвлөх нь орон нутгийн эдийн засгийн өсөлт, ажлын байр нэмэгдүүлэх, тогтвортой орлогын баазыг бэхжүүлэхэд макро түвшний үр нөлөө үзүүлэх тул цаашид энэ чиглэлийн бодлогын уялдааг хангах шаардлагатай байна.

2.1 Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих санд төсөв баталж ажлын байрыг нэмэгдүүлэх шаардлага байна.

2.1.1. Жижиг, дунд, үйлдвэрлэл, үйлчилгээг дэмжих тухай хуулийн 9.1.2-д заасан ЖДҮ, үйлчилгээний дэд бүтцийн хангамжийг сайжруулах ямар хэрэгцээ, шаардлага байгааг тодорхойлоогүй, шаардлагатай төсөл арга хэмжээг орон нутгийн төсвийн төсөлд тусгаагүй байна. Мөн хуулийн 18.1.1 дэх “тухайн шатны жил бүрийн төсөвт жижиг, дунд үйлдвэр, үйлчилгээг хөгжүүлэх зориулалтаар хөрөнгө тусгаж батлах” заалтын хүрээнд улсын ЖДҮ-ийг дэмжих санд жил бүр 300.0 сая төгрөг олгохоор баталж байсан бөгөөд 2026 оны төсвийн төсөлд “Сүү, сүүн бүтээгдэхүүний үйлдвэрлэлийг нэмэгдүүлэх” төсөл арга хэмжээнд төлөвлөсөн байна. Харин тухайн төсөл, арга хэмжээний нэр тодорхой бус, тооцоо судалгаагүй байна.

2.1.2. Орон нутгийн хөгжлийн сангийн үйл ажиллагааны журмын 4.2.7, 4.4.7-д заасны дагуу өрхийн орлогыг дэмжих чиглэлээр иргэдийг чадавхжуулах сургалтын төсөл арга хэмжээг төлөвлөөгүй байна. Мөн журмын 4.2.8, 4.4.8-д заасны дагуу ажлын байр бий болгох боломжтой байх боловч өрхийн бичил үйлдвэрлэл эрхлэгч нарт зориулсан хөнгөлөлттэй үнээр түрээслүүлэх боломжтой инженерийн дэд бүтцэд холбогдсон барилга, байгууламжийг барих төсөл арга хэмжээг төлөвлөх шаардлагатай байна.

2.1.3. Сүхбаатар аймгийн ХХҮГ-ын ХЭДС-ийн хэрэгжүүлж буй хөтөлбөр, төслүүд эрэлт хэрэгцээ ихтэй байдаг байна. Тухайлбал дараах дэмжлэгүүд эрэлттэй байна. Үүнд:

- “Малгүй болон цөөн малтай малчин өрхийг малжуулах санхүүгийн дэмжлэг олгох”
- “Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөр”
- “Шилдэг Старт-Ап залуу, залуучуудын багт санхүүгийн дэмжлэг олгох”

2.1.4. Иймд Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хуулийн 22.1.2-т заасны дагуу орон нутгийн төсвөөс аймгийн ХЭДС-д төсөв батлах асуудлыг шийдвэрлэх нь орон нутгийн хөгжил, иргэдийн ажилтай, орлоготой байх нөхцөлийг бүрдүүлэхэд дэмжлэг болох юм.

2.2 Хөгжлийн төлөвлөгөөний төсөл, арга хэмжээ төсвийн төлөвлөлттэй уялдсан эсэхэд дүгнэлт өгөх боломжгүй байна.

2.2.1 Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.10.4-т орон нутгийн төсөв нь аймаг, нийслэл, хотын хөгжлийн жилийн төлөвлөгөөг хэрэгжүүлэхэд чиглэсэн байх, мөн тус хуулийн 18.5-д хөгжлийн асуудал хариуцсан аймаг, нийслэлийн байгууллагууд Улсын хөгжлийн жилийн төлөвлөгөөнд суурилсан хөгжлийн жилийн төлөвлөгөөний төслийг 9 дүгээр сарын 01-ний дотор боловсруулж, тухайн оны 10 дугаар сарын 01-ний өдрийн дотор ИТХ-аар батлуулах үүрэгтэйг заасан. Аймгийн хөгжлийн жилийн төлөвлөгөөг хуулийн хугацаанд батлуулаагүй нь хуулийн хэрэгжилтэд нийцээгүй нөхцөл байдал үүсэж байна.

2.2.2 Иймд аймгийн хөгжлийн жилийн төлөвлөгөөг шалгуур үзүүлэлт, хүрэх үр дүнг хэмжигдэхүйц байдлаар төлөвлөсөн эсэх болон хөгжлийн төлөвлөгөөний төсөл, арга хэмжээ төсвийн төлөвлөлттэй уялдсан эсэхэд дүгнэлт гаргах боломжгүй байгааг дүгнэж байна.



Холбогдох байгууллагын санал:



СҮХБААТАР АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР

Сүхбаатар, Баруун-Урт, 7-р баг, Нутгийн удирдлагын
ордон

Утас: 70518585, Факс: 70518585

Цахим шуудан: info@sukhbaatar.gov.mn

Цахим хуудас: Sukhbaatar.gov.mn

2025.12.02 № 06/1398

танай _____-ны № _____-т

“СҮХБААТАР АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН” АУДИТЫН ГАЗАРТ

“Тайлбар хүргүүлэх тухай”

Орон нутгийн 2026 оны төсвийн төсөлд дүгнэлт өгөх нийцлийн аудитын тайлантай танилцлаа. Тайланд тусгагдсан төсвийн орлого, урсгал зардалтай холбоотойгоор дараахь тайлбарыг хүргүүлж байна. Үүнд:

1. “Агаарын бохирдлын төлбөрийн тухай хууль”-ийн 7 дугаар зүйлийн 7.1 дэх хэсэгт Олборлосон түүхий нүүрсний төлбөрийн хувь, хэмжээг нүүрсний килограмм тутамд 1-2 төгрөгийн хязгаарт багтаан аймаг, нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, улсын зэрэглэлтэй хотын Зөвлөл тогтооно гэж заасны дагуу төлбөрийн хувь хэмжээг тогтоох асуудлыг аймгийн ИТХ-аар хэлэлцүүлэн шийдвэрлүүлэхээр хэлэлцэх асуудлын төлөвлөгөөнд оруулан холбогдох материалыг хүргүүлсэн. Ийм учир эрх зүйн актын хүчин төгөлдөр байдал хангагдана гэж үзэж байна.

2. Түгээмэл тархацтай ашигт малтмал ашиглахтай холбоотой зөрчилд холбогдох улсын байцаагч 181.3 сая төгрөгийн нөхөн төлбөрийг Байгаль орчин, уур амьсгалын сангийн дансанд төвлөрүүлэхээр шийтгэлийн хуудас бичсэн бөгөөд орон нутгийн төсөвт төвлөрүүлэх асуудлаар аймгийн ЗДТГ-ын СТСХ-ийн дарга тухайн улсын байцаагчтай холбогдож хууль тогтоомжийн хүрээнд судлан ажиллаж байгаа болно. Мөн Хууль эрх зүйн хэлтэстэй хамтран ажиллаж байна.

3. Аймгийн ИТХ-аас 2011 оны 3 дугаар сарын 29-ний өдрийн 03 тоот тогтоолоор авто авто тээврийн хэрэгсэлд ногдох татварын хэмжээг тогтоосон. Үүнээс хойш татварын хувь хэмжээг шинэчлэн тогтоогоогүй. Татварын хувь хэмжээг нэмэгдүүлэх нь нэг талаас орон нутгийн төсвийн орлого нэмэгдэх сайн нөлөөтэй боловч нөгөө талаас иргэдийн амьжиргаанд нөлөөлөх, татвараас зайлсхийж татварын бааз суурийг хумих үр дагавар үүсэх магадлалтай. Сүхбаатар аймагт бүртгэлтэй нийт 15176 тээврийн хэрэгслийн 88 хувийг иргэдийн хувийн тээврийн хэрэгсэл эзэлдэг. Татвар хураалтыг сайжруулж хамрах хүрээг өргөн байлгах нь өндөр татвар төлөхөөс илүү ач холбогдолтой байна гэдэг

үндэслэлээр ИТХ-аар хэлэлцэхээс хойшлуулж байсан. Татварын хувь хэмжээг нэмэгдүүлэх нь иргэдэд дарамт үүсгэдэг бөгөөд мөн хууль тогтоомжийн дагуу судалгаа, тооцоолол хийх, хэд хэдэн үе шаттай хэлэлцүүлэг, сонсох ажиллагааг зохион байгуулах процесстой тул энэ асуудлаар аймгийн ЗДТГ, аймгийн Татварын газар судалгаа хийж байгаа болно.

4. 2025 онд уул уурхайн үйл ажиллагаа эрхэлдэг аж ахуйн нэгжүүдтэй байгуулсан хамтран ажиллах гэрээгээр 3,880.0 сая төгрөг төвлөрөхөөс 2025 оны 11-р сарын 19-ны байдлаар 3,278.0 сая төгрөг буюу 84,5 хувь нь төвлөрч 602.0 сая төгрөгийн орлого дутуу төвлөрсөн. Энэ орлогыг 2025 онд төсөвт төвлөрүүлэх зорилготойгоор хариуцсан мэргэжилтэн, хэлтсийн дарга нар компаниудтай холбогдон ажиллаж байна.

5. Ус рашаан ашигласны төлбөрийн гэрээг Байгаль орчны газар болон сав газруудтай байгуулсан 9 аж ахуй нэгжүүд байгаа боловч өнөөдрийн байдлаар 6 аж ахуй нэгж үйл ажиллагаа явуулаагүй, зогссон байдалтай Хунт өгөөж, Эрдэнэнийн босго, Олгой булаг ХХК-иас ус ашигласны төлбөр 12 сарын 1-ны байдлаар 55,6 сая төгрөгийн татварыг төвлөрүүлсэн нь дээрхи орлогыг гэрээ байгуулсан дүнгээр тооцох боломжгүй байна.

6. Аймгийн ИТХ-ын төсвийн төсөлд төлөөлөгчийн үйл ажиллагаа болон чадавхжуулах зардлыг 290.0 сая төгрөгөөр (нэг төлөөлөгчид 10.0 сая төгрөг ногдохоор тооцсон), мөн 2025 оны төсвийн жилд хэрэгжүүлээгүй үйл ажиллагаанд 80.0 сая төгрөгөөр тус тус төлөвлөсөн. Аймгийн ИТХ-ын төлөөлөгчид 2025 оны төсөвт сонгогдсон тойрогтоо ажиллах төлөвлөгөө гаргаж үйл ажиллагаагаа хэрэгжүүлсэн боловч төсвийн тодотголоор хөрөнгө хасагдсан учир өр, авлага үүсгэсэн. Ийм учир үүнийг барагдуулах зүйлшгүй шаардлага бий болж 2026 оны төсөвт нэмж тусгасан болно. Аймгийн ИТХ-ын төлөөлөгчдийг чадавхжуулах зардлыг 145.0 сая төгрөгөөр нэмэгдүүлэн тооцсон бөгөөд энэ асуудлыг хууль тогтоомжид нийцүүлэн залруулна.

7. Хууль, эрх зүйн актуудад нийцэхгүйгээр төлөвлөгдсөн болон олгогдсон тэтгэмжийн нийт 188.8 сая төгрөгийн зардлыг 2026 оны төсвийн төслөөс хасаж тооцон төсвийн төсөлд өөрчлөлт орууллаа.

8. Аймгийн 2026 оны төсвийн төсөлд гэрээгээр гүйцэтгүүлэх арга хэмжээ (ОНӨҮГазар)-нд 1,255.0 сая төгрөг зарцуулахаар төлөвлөсөн. Энэ нь төрийн зарим үйл ажиллагааг тухайн чиг үүргийг төрийн бус байгууллага болон аж ахуйн нэгж байгууллагуудаар гүйцэтгүүлэх зайлшгүй шаардлага үүссэнтэй холбоотой юм. Тухайлбал, Сүхбаатар соёл амралтын хүрээлэн ОНӨААТҮГ нь улс, орон нутгийн төсөв, төсөл хөтөлбөр, хандив дэмжлэгээр нийт 27,2 тэрбум төгрөгийн хөрөнгөөр бүтээн босгосон байгууламжийг хэвийн үйл ажиллагааг хангах, ногоон байгууламжийг бий болгох, усалгаа арчилгаа хийх, зам талбайн цэвэрлэгээ үйлчилгээг хариуцах зэрэг ажлуудыг гүйцэтгэх юм. Энэ байгууламж бол Баруун-Уртын голын ундаргыг хамгаалж, урсах түвшинг сайжруулан

байгалийн онгон төрхөөр нь хадгалах, агаарын бохирдлыг бууруулан ногоон байгууламжийг нэмэгдүүлж, эрүүл эко орчныг бүрдүүлэн олон нийтийн амралт, чөлөөт цагийг зөв зохистой өнгөрүүлэх үйл ажиллагааны стандартад нийцсэн амралт зугаалгын цогцолбор төв болгох үндсэн зорилготой нийт ард иргэдэд зориулагдсан учир үйл ажиллагаа нь жигдэрч бие даан ажиллах хүртэл орон нутгийн дэмжлэг шаардлагатай гэж үзэж байна. Орлогыг 259,0 сая төгрөг байхаар тооцсон.

"Сүхбаатар хөгжил УТП" ОНӨААТҮГ нь 2026 онд аймгийн Засаг даргын 2024-2028 оны хөтөлбөрийн "Орон нутгийн сүү боловсруулах үйлдвэрийг ашиглалтад оруулна" гэж тусгагдсан 3.8.2.3 заалтыг хэрэгжүүлэн ажиллахаар үйлдвэрийг байгуулан ашиглалтанд оруулаад байна. Үйлдвэр тогтвортой ажиллах нь дараах боломжуудыг бий болгоно. Эхний зорилго Баруун-Урт сумын сургууль, цэцэрлэгийн 8,634 хүүхдийн сүүний хэрэгцээг (1295 л/өдөр) хангах юм. Энэ зорилтыг хэрэгжүүлснээр дараах үр дүн бий болно:

-Малчдын орлого ба Урамшуулал: Одоогоор үйлдвэрт тушаасан сүүг 3,500₮-өөр тогтмол худалдан авч малчдад орлого оруулахаас гадна ХХААХҮЯ-ны сүүний урамшуулалд хамрагдаж литр тутамд 1000 төгрөг авах боломжийг олгоно. Жилд 194.3 сая ₮-ийн урамшуулалд хамрагдана.

-Орон Нутгийн Төсвийн Орлого: Төсвийн тухай хуулийн дагуу иргэдийн орлогын албан татвар (ХХОАТ) нь тухайн орон нутгийн төсөвт (сум/аймаг) хуримтлагдана 170.5 сая ₮-ийн ХХОАТ (малчдын, ажилчдын орлогоос) орон нутгийн төсөвт тогтмол төвлөрнө.

-Хөрөнгө Оруулалтыг Өдөөх: Дээрх тооцооллын дагуу шаардлагатай 1295 л сүүг бэлтгэн нийлүүлэхийн тулд ойролцоогоор 37 өрх тогтвортой үйл ажиллагаа явуулж, малын тэжээл тариалалт, мал эмнэлэгийн үйлчилгээ үзүүлэх зэргээр 30-аас дээш ажлын байр бий болно. Иймд энэ үйлдвэрийн нийгмийн үр өгөөж нь санхүүгийн ашгаас хамаагүй өндөр бөгөөд төрийн дэмжлэг зайлшгүй шаардлагатай гэж үзсэн. Зардлынхаа тодорхой хэсгийг өөрийн орлогоороо санхүүжүүлнэ.

Сүхбаатар нийтлэг үйлчилгээ ОНӨААТҮГ нь аймгийн Ахмадын амралт сувилалын газрыг хариуцан ажилладаг учир энэ чиглэлээр зарим санхүүгийн дэмжлэг олгохоор тусгасан. Бусад үйл ажиллагаагаа өөрийн орлогоор санхүүжүүлнэ.

Теле камерын хяналтын дэд төвийг байгуулан ажиллуулах талаар Монгол Улсын Засгийн газрын 2024 оны 86 дугаар тогтоолоор аймгуудын Засаг дарга нарт үүрэг болгосон. Энэ үйл ажиллагааг 2025 онд Баруун-Урт сжм хариуцан хэрэгжүүлсэн. Энэ төв нь зөвхөн Баруун-Урт сумын үйл ажиллагааг хамаарахгүй, сумдыг ч холбох учир дэд төвийн зардлыг аймгийн төсөвт тусган 300,0 сая төгрөгийг гэрээгээр гүйцэтгүүлэх ангилалд хамруулсан болно.

Тайланд тусгагдсан санал, зөвлөмжийг судлан хэрэгжүүлж ажиллана.



Сүхбаатар аймгийн засаг даргын тамгын газар
Санхүү, төрийн сангийн хэлтэс
Хэлтсийн дарга
Дугарболд Ариунжаргал
2025-12-02 11:21:24



СҮХБААТАР АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ТАМГЫН ГАЗАР

Сүхбаатар, Баруун-Урт, 7-р баг, Нутгийн удирдлагын
ордон

Утас: 70518585, Факс: 70518585

Цахим шуудан: info@sukhbaatar.gov.mn

Цахим хуудас: Sukhbaatar.gov.mn

2025.12.02 № 05/1397

танай _____-ны № _____-т

Тайлбар хүргүүлэх тухай

Орон нутгийн 2026 оны төсвийн төсөлд өгсөн дүгнэлт, зөвлөмжийн дагуу дараах тайлбарыг хүргүүлж байна.

-Төсвийн тухай хуулийн 60.3.6 дахь заалтад орон нутгийн иргэдийн санал аваагүй, орон нутгийн төсвийн төлөвлөгөөнд тусгаж батлаагүй зардал арга хэмжээнд зарцуулахыг хориглоно. Түүнчлэн ОНХС журмын 4.7.5 дахь заалтад ОНХС хөрөнгийг Орон нутгийн иргэдийн саналыг аваагүй, орон нутгийн төсвийн төлөвлөгөөнд тусгаж батлаагүй зардал, арга хэмжээнд зарцуулахыг хориглоно гэж заасан байдаг.

Дээрх заалтуудын дагуу ОНХС төсөл арга хэмжээг боловсруулахдаа Аймгийн Засаг даргын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр, тухайн жилийн хөгжлийн жилийн төлөвлөгөө болон иргэдийн саналд үндэслэн боловсруулсан болно.

-Улсын хэмжээнд барилга байгууламжийн зураг төслийг магадлалаар баталгаажуулдаг "Барилгын хөгжлийн төв" төрийн өмчит үйлдвэрийн газар үйл ажиллагаа явуулдагтай холбогдон зарим төсөл арга хэмжээний зураг төсөв магадлалын дүгнэлт хүлээгдэж байна.

-Төсвийн бус эх үүсвэрээр буюу олон улсын байгууллагын төсөл хөтөлбөрийн санхүүжилтээр иргэд, аж ахуйн нэгж, хоршоод руу аж ахуй эрхлэх хорших сургалтуудыг үе шат дараатай мэргэжлийн байгууллага, зөвлөлүүд хамтран зохион байгуулж байна. Тухайлбал: НҮБ-ийн ХХАА байгууллага, Хуурай хээрийн ландшафт, биологийн олон янз байдлын төсөл, Адапт, Цогц эрүүл мэндийн төсөл гэх мэт төслөөр дамжуулан хэрэгжүүлж байна.

Дүгнэлтийн хүрээнд хөрөнгө оруулалтын төлөвлөлтөд анхаарч зөвлөмжүүдийг цаашид хэрэгжүүлэн ажиллахаа үүгээр илэрхийлж байна.



Сүхбаатар аймгийн засаг даргын тамгын газар
Хөгжлийн бодлого төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтэс
Хэлтсийн дарга
Гомбожав Мөнхзаяа
2025-12-02 09:04:13

Ирүүлсэн саналд өгсөн тайлбар:

Санхүү, төрийн сангийн хэлтсээс ирүүлсэн саналд дараах тайлбарыг өгч байна. Үүнд:

Тайлбар 1	Төсвийн төсөлд өгөх саналаас орон нутагт орох уул уурхайн хамтарсан гэрээний орлогыг хасаж тооцов.
-----------	--

ДУГНЭЛТ:

Аудитын дүнд үндэслэн дараах дүгнэлтийг гаргаж байна.

1. Орон нутгийн төсвийн орлогын төлөвлөлтийг оновчтой боловсруулж, боломжит эх үүсвэр бүрийг бүрэн тооцоолж, орлогын гүйцэтгэлийг тогтмол хянах замаар орлогыг нэмэгдүүлэх боломжтой байна.
2. Зарлагын төлөвлөлт нь өмнөх онтой харьцуулахад бууралттай гарсан хэдий ч зарим зардлыг холбогдох хууль, эрх зүйн зохицуулалтад нийцүүлээгүй, мөн төлөвлөлтийн үндэслэл, тооцоо судалгаа хангалтгүйгээс шалтгаалан бодит бус дүнгээр тусгасан нь цаашдын төсвийн гүйцэтгэл, санхүүгийн сахилга, хариуцлагад сөрөг нөлөө үзүүлэх эрсдэлтэй байна.
3. Орон нутгийн төсвийг төлөвлөхдөө хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, ЖДҮ-ийг хөгжүүлэх бодлоготой уялдуулан төлөвлөснөөр макро эдийн засгийн түвшинд оновчтой шийдэл болохоор байна.
4. Өмнөх онтой харьцуулахад хөрөнгө оруулалтын төлөвлөлт зарим төсөлд зураг төсөв, техникийн баримт бүрдүүлэлт сайжирсан боловч ОНХС-ийн олон нийтийн оролцооны шаардлага, техникийн тодорхойлолт, үнийн судалгааг захиалагчийн түвшинд бүрэн хийгдээгүй зэрэг төлөвлөлтийн зарчим бүрэн хангагдаагүй байна.
5. Ажлын байр нэмэгдүүлэхэд чиглэсэн бодлогын хүрээнд ЖДҮ-ийн дэд бүтэц, өрхийн орлогыг дэмжих сургалт, бичил үйлдвэрлэлийн дэмжлэг, ХЭДС-ийн санхүүжилт зэрэг шаардлагатай чиглэлүүд төсвийн төсөлд тодорхой тусгагдаагүй бөгөөд хэрэгцээ, судалгаа, зорилтот үр дүнг тодорхойлоогүй нь төсвийн бодлогын нөлөөллийг бууруулж байна.

ТӨСВИЙН ТӨСӨЛД ӨГӨХ САНАЛ:

1. Орон нутгийн төсвийн орлогыг 626.2 сая төгрөгөөр (ус ашигласны төлбөр 626.2 сая) орлогыг нэмэгдүүлэх боломж байна.
2. Агаарын бохирдлын төлбөрийн хувь хэмжээг ИТХ-аар батлаагүй нөхцөлд төлбөрийн орлогыг килограмм тутамд 2 төгрөгөөр тооцон төлөвлөсөн нь хууль, эрх зүйн нийцэлгүй, бодитой төлөвлөлт болохгүй байна.

Иймд төлбөрийн хувь хэмжээг тогтоох эрх зүйн актыг төсвийн төслийн хамт ИТХ-д өргөн мэдүүлж, нэгэн зэрэг батлуулах шаардлагатай. Ингэснээр татварын бааз суурь хууль ёсоор бүрдэж, төлбөрийн орлого бодитоор төвлөрөх нөхцөл хангагдана. Үүнийг баталгаажуулснаар төсөвт 6,000.0 сая төгрөгийн орлого төвлөрөх боломж нь бүрдэхээр байна

3. Төсвийн төлөвлөлтийг нотолгоо, баримтад тулгуурлан боловсруулах, хууль эрх зүйн шаардлагыг хангах үүднээс дараах зардлын төлөвлөлтийг дахин хянаж, төсвийн зардлыг бууруулах арга хэмжээг авах нь зүйтэй байна Үүнд:
- Засгийн газрын 2021 оны 402 дугаар тогтоолоор баталсан журмын дагуу төлөөлөгчийн үйл ажиллагаа болон тэдгээрийг чадавхжуулах зардлыг тооцоход 145.0 сая төгрөгийг төлөвлөх боломжтой бөгөөд үүнээс давсан 145.0 сая, 2025 оны төсвийн жилд хэрэгжүүлээгүй үйл ажиллагаанд 80.0 сая нийт 225.0 сая төгрөгийн зардлыг төсвөөс хасаж тооцох
 - Тайлант жилд олгосон болон холбогдох хууль, эрх зүйн актуудад нийцэхгүйгээр төлөвлөгдсөн тэтгэмжийн нийт 188.8 сая төгрөгийн зардлыг 2026 оны төсвийн төслөөс хасаж тооцох
 - Сүхбаатар соёл амралтын хүрээлэн, Сүхбаатар хөгжил ҮТП, Бичигт их өргөө, Сүхбаатар нийтлэг үйлчилгээ зэрэг ОНӨААТҮГ-ын үндсэн үйл ажиллагаатай холбоотой орлогыг тооцоолж, аймгийн төсвөөс олгох санхүүгийн дэмжлэгийг бууруулах боломжийг судлах
 - Ус цэвэршүүлэх болон бохир усны байгууламжийн урсгал зардалд 386.2 сая төгрөгийг орон нутгийн төсвөөс санхүүжүүлэх эрх зүйн үндэслэл байхгүй бөгөөд хуульд нийцээгүй төлөвлөлт хийгдсэн тул 2026 оны төсвийн төслөөс хасаж тооцох нь зүйтэй юм.
4. Ажлын байр нэмэгдүүлэх бодлогыг үр нөлөөтэй хэрэгжүүлэхийн тулд ЖДҮ-ийн дэд бүтэц, өрхийн орлогыг дэмжих, Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн (ХЭДС) санхүүжилтийн хэрэгцээ, шаардлагатай хөрөнгийн тооцоо судалгааг хийж төсвийн төсөлд тусган баталгаажуулах шаардлагатай. Ингэснээр төсвийн бодлогын нөлөөллийг нэмэгдүүлж, бодит ажлын байр бий болгох боломж бүрдэх юм.
5. Шинээр төлөвлөгдсөн 7,097.3 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 29 төсөл арга хэмжээ магадлалаар баталгаажсан зураг төсөвгүй, төсөвт өртгийн тооцоо судалгаагүй, техникийн тодорхойлолт, үнийн судалгаагүй байгаа нь төсөвлөлтийн шаардлагыг хангахгүй байх тул эдгээр төсөл, арга хэмжээний төлөвлөлтийг дахин нягталж үзээд, шаардлага хангахгүй төсөл, арга хэмжээнүүдийг хасуулах саналтай байна.
6. Төсөвлөлтийн шаардлага хангаагүй, магадлалаар баталгаажгаагүй зураг төсөлд үндэслэн төлөвлөлт хийж байгаа нөхцөлд 1-рт магадлалын дүгнэлт тогтоолын дүнгээс өндөр гарах, улмаар тендер шалгаруулалт зохион байгуулах боломжгүй болох, ажлын тоо хэмжээг хасаж тендер зарлах сөрөг үр дагавартай, 2-рт магадлалын дүгнэлт тогтоолын дүнгээс багаар батлагдсан тохиолдолд хэмнэгдсэн төсөв нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 13.1.3 /хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний худалдан авах ажиллагааны үр дүнд бий болсон хэмнэлтийг зарцуулахгүй байх/ дахь заалтаар зарцуулах боломжгүй болж, төсвийн хөрөнгийн зарцуулалтын үр ашиг буурахаар байна.

ЗӨВЛӨМЖ:

Аудитын дүн, дүгнэлт нотлох зүйлст үндэслэн дараах зөвлөмжийг өгч байна. Үүнд:

Аймгийн Засаг даргад:

1. Төсвийн орлого бүрдүүлэлтэд нөлөө бүхий хууль, эрх зүйн хэрэгжилт, байгууллагуудын уялдаа холбоо, дотоод хяналт, мэдээллийн системийн нэгдмэл байдал зэрэг хүчин зүйлсийн зохион байгуулалт, хяналтыг сайжруулах замаар төсвийн орлогын боломжит эх үүсвэрийг бүрэн тооцоолон орон нутгийн төсөвт төвлөрүүлэх арга хэмжээг хэрэгжүүлэх
2. Төсвийн зарлагыг хөтөлбөрөөр төлөвлөхдөө төслийн ач холбогдол, эрэмбэ, хэрэгцээ шаардлагын үнэлгээ, олон нийтийн оролцоо, төсөвлөлтийн норм, норматив, батлагдсан стандарт болон зураг төсвийг тусган тодорхойлох
3. Аймгийн ИТХ-аас 2011 оны 03-р сарын 29-ний өдрийн 03 тоот тогтоолоор авто тээврийн хэрэгсэлд жилд ногдох хэмжээг тогтоосон. Жилд ногдох татварын хэмжээг хуулийн хязгаарт багтаан шинэчлэн тооцоолж, төсвийн орлогыг нэмэгдүүлэх арга хэмжээ авч ажиллах
4. Аймгийн ИТХ-аар түгээмэл тархацтай ашигт малтмалын борлуулалтын үнэлгээг батлуулж, татварын төлбөрийг бүрэн төвлөрүүлэх зохицуулалт хийх

АЗДТГ-ын БОНХОБТХэлтэст:

1. ОНХС-ын журмын дагуу бүх төсөл, арга хэмжээг иргэдийн саналд үндэслэн урьдчилсан жагсаалтад оруулж, нээлттэй хэлэлцүүлгийг зохион байгуулан баримтжуулж, хэлэлцүүлэггүй төслүүдийг төсвийн төсөлд тусгахгүй байх.
2. Тоног төхөөрөмж, барилга байгууламжийн ТЭЗҮ, техникийн тодорхойлолт, зураг төсөв, зах зээлийн үнийн судалгааг баталгаажуулж, эдгээр баримт бичгийг бүрдүүлээгүй төслийг төлөвлөлтөд оруулахгүй байх.
3. Өрхийн амьжиргааны түвшнийг дээшлүүлэх чиглэлээр өндөр хөгжилтэй орнуудад хамтын эдийн засгийг хөгжүүлсэн байх тул, төмс, хүнсний ногооны тариалалт, тахианы аж ахуй, малын тэжээлийн тариалалт гэх мэт чиглэлээр иргэд, өрх олноороо хорших, хамтрахын ач холбогдлыг түгээн дэлгэрүүлэх чиглэлээр сургалт, сурталчилгаа төсөл, арга хэмжээг төлөвлөх.